

8

УЛСЫН СЕКТОРЫН УДИРДЛАГЫН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Н.Тунгалаг, Д.Авирамэд

ХУРААНГҮЙ

Улсын секторт удирдлага, хяналтын тогтолцоо боловсронгүй бус байгаагаас төсвийн хөрийнгийн ашиглалт, зарцуулалтын үр ашигт соргоор нолоолох болсон. Удирдлагын хяналтын тогтолцооны анхдагч элементүүдийн нэг нь төсөвлөлт бөгөөд түүнийг орчин үсийн арга технологиор баяжуулан практикт хэрэглэх нь Улсын болон хувийн секторт нооцийн эдийн засгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх гол хүчин зүйлсийн нэг юм.

Удиртгал

Монгол улсын Үндсэн хуулинд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны овормөн онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгтай байна”¹⁸ хэмсэн заасан нь хүн төрөлхтний ололтыг хүндэтгэн үзэж, түүхэн уламжлалаа хадгалсан нийгэм эдийн засгийн тогтолцоо бүрдүүлэх үндэс суурийг тавьсан.

Орчин үеийн нийгмийн хөгжлийн хандлагад нийцүүлэн удирдлага, хяналтын тогтолцоог боловсронгүй болгох хэрэгцээ шаардлага улсын болон хувийн аль ч секторын өмнө тулгарч байсан бөгөөд тэдгээр асуудлуудыг зохих түвшинд шийдвэрлэж ирсэн билээ.

Манай улс удирдлага, санхүүгийн хяналтын эртний уламжлалтай бөгөөд түүний зарим элементүүд цаг үеийн болон нийгэм эдийн засгийн хөгжлийн шаардлагаар бие даасан салбар ухаан болон хөгжиж ирсэн хэдий ч тэдгээрийг

¹⁸ [www.http://legalinfo.mn](http://legalinfo.mn) “Монгол Улсын үндсэн хууль” 5 дугаар зүйлийн 1 дэх заалт

судлан, хөгжлийн өнөөгийн түвшинд нийцүүлэх шаардлага амьдралаас урган гарч байна.

Судалгааны ажлын зорилго

Улсын секторын удирдлагын хяналтын тогтолцооны онол, арга зүйг судлан, уг тогтолцооны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид түүнийг төсвийн хөрөнгийн ашиглалт, үр ашигийг дээшлүүлэх боловсронгүй арга хэрэгсэл болгон ашиглах оновчтой хувилбарыг боловсруулахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Улсын секторын удирдлагын болон санхүүгийн дотоод хяналтын тогтолцооны онол, арга зүй

Удирдлагын шинжлэх ухаанд удирдлагын үүргийг “төлөвлөлт, зохион байгуулалт, урамшуулалт, хяналт зохицуулалт” хэмээн тодорхойлдог бөгөөд энэ талаар мэргэжилтнүүд нэгдсэн нэг ойлголтонд хүрсэн¹⁹ гэж үздэг байна. Удирдлагын эдгээр үүргүүд нь эргэх холбоо бүхий тасралтгүй процесс байх ба төлөвлөгөөний биселэлтийг гүйцэтгэлтэй нь харьцуулан хэлбэлзлийг арилгах арга хэмжээ авснаар энэхүү эргэх холбооны механизм хангагдаж байдаг. Энэ нь удирдлагын хяналтыг үүсгэдэг. Ийнхүү удирдлагын үүргүүдээр холбогдсон энэхүү гинжин хэлхээг удирдлагын хяналтын тогтолцоо гэх бөгөөд уг тогтолцоо орц, үйлдэл, гарц гэсэн элементүүдээс бүрдэнэ.

Орц:

Тосов, толовлогоо

Үйл ажиллагаа, тохируулга:

Бүртгэл, тайллагнал

Гарц:


Гүйцэтгэл

Дүрслэл. Удирдлагын хяналтын тогтолцоо

Аливаа тогтолцооны бүтэц, байгууламжуудыг салгах биш, аль болох үндсэн тогтолцоонд уяж, холбоосыг нь мэдрэх нь чухал болж байна²⁰ гэж эрдэмтэд үзэж байна.

Удирдлагын хяналтын тогтолцоо нь эдийн засаг хэмээх үндсэн тогтолцооны дотор байршиж, түүний орчны хүчин зүйлс, хувьсагчдын нөлөөнд оршино.

Манайд бүрэлдэн тогтсон эдийн засгийн тогтолцоо бол “терийн зохицуулалттай зах зээлийн эдийн засаг” мөн бөгөөд Ж.М Кейнсийн онолд багтана. Удирдлагын хяналтын тогтолцооны макро орчин нь энэхүү терийн зохицуулалттай эдийн



¹⁹ Н.Тунгалаг. “Удирдлагын бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх зарим асуудал” Диссертаци..., УБ 1999 он., Хуудас 13

²⁰ Жааваа Т. Нягтлан бодох бүртгэлийн онол, арга зүй: Зардал удирдлагын бүртгэл дэх хувьсагчид ба сургалтын хандлага. “Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт” улирал тутмын сэргүүл №1 (3) 2010 он хуудас 2

засгийн тогтолцоо, гадаад микро орчин нь энэ тогтолцооны элементүүд байх ба дотоод бүтэц бүрэлдэхүүний гол цөм нь маркетинг, менежмент, нягтлан бодох бүртгэл байна.

Оноөдор удирдлагын хяналтын тогтолцооны гадаад, дотоод орчны нөлөөлөл, түүний өөрчлөлтийн улмаас улсын болон хувийн аль ч секторын удирдлагын өмнө эдгээр өөрчлөлт болон нийгэм эдийн засгийн хөгжлийн шаардлагаар байгууллагын үнэлэмжийг өсгөх, сайи засаглалыг бэхжүүлэхтэй холбоотойгоор удирдлагын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, шинэ шатанд гаргах хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Удирдлагын хяналтын тогтолцооны хөгжлийг судлаачид хэд хэдэн үе шатаар авч үздэг бөгөөд тоймлон үзвэл дараахь үе шатуудтай болж байна. Үүнд:

Хөгжлийн гарааны зурвас үе: Удирдлагын хяналтын тогтолцоонд өөрчлөлт шинэчлэл хийж эхэлсэн үе богоод ўламжлалт ортгийн систем- гүйцэтгэлийн хяналт болон энгийн тосовлөлтийн систем, эдгээртэй холбоотойгоор үйлдэхүүний стратеги бүрэлдэн тогтсон. Тэр үед бүрэлдэн тогтсон уг системийн үндсэн элементүүд, тухайлбал, суурь төсөв, гүйцэтгэлийн бүрэн зардал, шууд өргтгийн систем, түүхэн болон өнөөгийн өртөг, нягтлан бодох бүртгэлийн болон эдийн засгийн ашиг зэрэг нь өнөөдор ч ач холбогдоо алдаагүй байгаа билээ.

Төлөвшлийн үе: Борлуулалтын стратеги дэлгэрч, стратеги төлөвлөлт, төсөвлөлт, сегментчилэл, хариуцлагын тайлагнал зэрэг гол гол удирдлагын хэрэгдүүр үүсч хожжсөн нь удирдлагын хяналтын тогтолцооны MCS байгууламжийн орчны хүрээг тэлэхэд хүргэсэн гэж үздэг.

Тулхтай хөгжил, даяаршилын үе: Маркетингийн стратегийг дэмжиж, удирдлагын хяналтын тогтолцоо сонгодог хэв маягаар загварчлагдах болсон. Энэ үед (ялангуяа сүүлийн 30-аад жилд) илэрч буй өөрчлөлтүүдийг нэгтгэн дүгнэж, дараахь 2 томоохон хувьсал гарч байна²¹ гэж үзжээ. Эдгээр нь:

1. Удирдлагын хяналтын орчны тэлэлтийн үзэгдэл
2. Удирдлагын хяналтын загварчлал юм.

Удирдлагын хяналтын орчин толж өргөн цар хүрээтэй маркетингийн стратегид чиглэж байна.

Удирдлагын хяналтын загварчлал. Стратегийн удирдлагад шилжсэнтэй холбоотойгоор өнөөдор баруунд удирдлагын хяналтын тогтолцоонд нэвтрээд байгаа “Тэнцвэрт онооны карт” нь энэ салбарын томоохон ололтын нэг мөн юм. Ахь 1990-ээд оны эхээр АНУ-ын эрдэмтэн судлаач Р. Каплан, Д.Нортон нар “тэнцвэрт онооны карт”-ыг санаачилж, нэвтрүүлсэн²² байдаг.


Ирээдүйн толов байдлыг илэрхийлэхэд зөвхөн санхүүгийн талаарх мэдээлэл хангалттай бус, үүнээс гадна хэрэглэгч, байгууллагын дотоод бүтэц, хөгжилт гэсэн хүчин зүйлүүдийн зөв хослол онцгой үүрэгтэй гэж Р. Каплан, Д.Нортон нар үзсэнээр уг загвараа боловсруулжээ. Энэ загвар нь удирдлагын хяналтын

²¹ Жааваа Т. Нягтлан бодох бүртгэлийн онол, арга зүй: Зардал удирдлагын бүртгэл дэх хувьслын чиг ба сургалтын хандлага. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт улирал тутмын сэргүүл №1 (3) 2010 он худас 1

²² www.senalosa.com/services/consulting

тогтолцооны бүтэц, байгууламж, холбоосуудыг сайжруулахад чиглэдэг бөгөөд дараахь элементүүдээс бүрддэг. Үүнд:

1. Санхүүгийн ирээдүйн толов
2. Хэрэглэгчийн ирээдүйн толов
3. Бизнесийн үйл ажиллагааны толов
4. Хүний нөөцийн хөгжилт, байгууллагын осолт орно. Үүнийг дүрслэн харуулвал:



“Тэнцвэрт онооны карт”-ын бүтэц

- **Санхүүгийн толов** – Орлого, капиталын огөож, эдийн засгийн үнэ цэнэ нэмэгдэлт зэрэг үзүүлэлтүүд.
- **Хэрэглэгчийн толов** – Хэрэглэгчийн сэтгэл ханамж, хэрэгцээ, зорилтот сегментийн зах зээлийн хувь оролцоо зэрэг хэмжилтүүд
- **Бизнесийн үйл ажиллагааны толов** – Зардал, чанар, аливаа өөрчлөлтийг шингээх чадамж зэрэг хэмжилтүүд.
- **Хүний нөөцийн хөгжилт, байгууллагын осолт** – Ажиллагсдын сэтгэл ханамж, ажиллах хүчиний хэрэгцээ, чадамж, хөгжүүлэлт зэрэг хэмжилтүүд орно.

Энэ 4 элемент нь бие даасан хэсгүүд боловч дангаараа орших боломжгүй, харин хоорондоо логик уялдаа холбоотой. Тухайлбал: осолт хөгжилт нь үйл ажиллагааг

удирдана, хэрэглэгчийн өмнө нэр хүнд, үнэ цэнийг өсгөнө, ингэснээр эцсийн дундээ санхүүгийн чадавхийг нэмэгдүүлж байдаг.

ТОК-н 4 элемент тус бүрийн зорилго, хэмжилтийн үзүүлэлтүүд, үзүүлэлтүүдийн зорилтот үнэ цэнэ, зорилтод хүрэх санаачлагыг агуулсан байх ба дараахь байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- **Зорилго – Хүрэх ёстой үндсэн зорилгууд**
- **Хэмжилт – Зорилгыг хамгийн тодорхой, ач холбогдол бүхий үзүүлэлт, параметрээр хэмжих. Жишээ нь, зорилтот ашигийн осолтийг цэвэр ашгийн өсөлтөөр хэмжих г.м.**
- **Зорилтот үнэ цэнэ – Зорилтуудыг тодорхой байдлаар илэрхийлнэ, жишээ нь цэвэр ашгийг 2% -иар өсгөнө г.м.**
- **Шинэ санаачлага - Тодорхой зорилгод хүрэхийн тулд нэвтрүүлэх шинэ санаачлага. Эдгээрийг хүснэгтээр илэрхийлвэл:**

	Зорилго	Хэмжилт	Зорилтот үнэ цэнэ	Санаачлага
Санхүү	*	*	*	*
Хэрэглэгч	*	*	*	*
Үйл ажиллагаа	*	*	*	*
Хөгжилт	*	*	*	*

Тэнцвэрт онооны карт

ТОК бол “стратегийн удирдлагын тогтолцооны үндсэн элемент” юм. Тэрээр, удирдлагын тогтолцоонд байгууллагын бүх түвшний стратегийн толөвлөлтонд дараахь үүрэгтэйгээр ашиглагддаг. Үүнд:

1. **Стратегийг тодорхойлох – Эрхэм зорилго буюу стратегийн зорилгыг үйл ажиллагааны зорилтууд болгож буулгах.**
2. **Стратегийн зорилтыг холбох – стратегийн зорилтыг тухайлсан гүйцэтгэлийн үзүүлэлтүүдэд нь уяж өгөх.**
3. **Бизнес төлөвлөгөө – Бизнес төлөвлөлт хийх, орчны өөрчлөлтүүдийг тусгах**
4. **Стратегийн эргэх холбоо ба сургамж – эргэх холбоог хангаж стратеги**

Байгууллагын стратегийн зорилгод хүрэх үе шатуудыг дүрсэлвэл:



Стратегийн удирдлагын тогтолцоо²³


Эндээс харахад стратегийн удирдлагын тогтолцоо нь ТОК-ийг **төсөвлөлт, тайлагнал, урамшуулалтай холбох үйл явц** болж байна. Эдгээр ухагдахуунууд нь удирдлагын бүртгэлийн элементүүд байдаг тул “стратегийн толөвлөлтийн гол арга зүй нь удирдлагын бүртгэлд тулгуурлана” гэдэг нь харагдаж байна.

Улсын секторын удирдлагын хяналтын тогтолцоо

Төр оорийн үүргээ биелүүлэхийн тулд оорийн бие даасан албан ёсны бүтэц, зохион байгуулалтыг бий болгоно. Энэхүү бүтцийг **улсын сектор хэмээн** нэрлэдэг.

²³ [www.http://Netmba.com/balanced-scorecard/](http://Netmba.com/balanced-scorecard/)

Улсын секторын удирдлага, зохион байгуулалт нь төрийн байгуулалтын үндсэн хэлбэр болох босоо тогтолцоогоор тодорхойлогдоно. Тухайлбал:



Төрийн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг оорийн хүчээр хуримтлуулж зарцуулах ба энэ монгон хоронгийн санг улсын төсөв гэдэг.

Удирдлагын үндсэн үүргүүд төрийн байгуулалтын бүтцийн аль ч түвшинд хэрэгжиж, удирдлагын хяналтын тогтолцоо төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад чиглэгдэж ирсэн. Улсын төсвийн онцлог нь микро түвшинд бүрэлдэж, макро түвшинд нэгтгэгдэн, эргэж микро түвшинд үйлчилдэг, үүнтэй холбоотойгоор удирдлагын хяналтын тогтолцоо ч микро ба макро түвшинг хамардаг явдал бөгөөд улсын төсвийн удирдлагын хяналтын үндсэн хэлбэр нь “төсвийн төлөвлөлт” болж байдаг билээ.

Төсвийн **орчин үеийн** шинэчлэл сүүлийн 20 -иод жил үргэлжилж байгаа богоод цаашид төсвийн зарлагын удирдлагыг шинэчлэхэд товлорох хандлагатай байгаа²⁴ ажээ. Монгол Улс 2003 оноос ТБУСТ хуулийг хэрэгжүүлж эхлэнээр Засгийн газрын дунд хугацааны зорилтуудыг тодорхойлж, түүний хэрэгжилтийг төсөвтэй уялдуулан үр дүнг тооцох болсон нь дэвшилтэй оорчлолт байсан. Гэвч оноогийн даяарчлагдсан шинжтэй улсын секторын төсвийн удирдлагын тогтолцооны өөрийн орны хүрсэн түвшинг зах зээлийн орнуудтай харьцуулахад төдийлон боловсронгуй бус тогтолцоо бүрэлдсэн байгааг хүлээн зөвшөөрч, цаашид боловсронгуй болгох асуудалд анхаарах нь зүйтэй.

Онөөдрийн манай практикт оршиж байгаа дутагдал бол Засгийн газар, салбар, байгууллагын аль ч түвшинд төлөвлөлтийг хийдээ зовхон үйл ажиллагааны хүрээнд авч үздэг, эдийн засгийн тооцоо судалгааг орхигдуулдаг, гаргасан тооцоо судалгаа үндэслэлгүй байх нь элбэг, төсвийн байгууллагууд төлөвлөлтийг хийдээ омнох жилийн гүйцэтгэлд үндэслэн түүнтэй ойролцоогоор төсөвлөдөг, энэ нь эргээд төсвийн хоронгийн үр ашиггүй зарцуулалтыг бий болгож байгаа явдал юм.

Улсын секторын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, төсвийн төлөвлөлтийг сайжруулж, шинэ шатанд гаргах арга зам нь түүний арга зүйг боловсруулах, тухайлбал удирдлагын бүртгэл, төсөвлөлтийн онол, арга зүйг

²⁴ Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл: Узэл баримтлал, хэрэгжилт. Удирдлагын академи.. УБ 2004 он

бүтээлчээр эзэмшиж, улсын секторын онцлогт тохируулан ашиглах явдал гэж бид үзэж байна.

Улсын секторын онцлог бол **гарц ба үр дүн** цаг хугацааны ялгаатай үеүдэд тодорхойлогддог явдал юм. Энэ нь нийгмийн асуудал маш олон хүчин зүйлийн нөлөөнд оршиж байдагтай холбоотой. Иймд төлөвлөлтийг эдгээр хүчин зүйлүүдтэй уялдуулан хийх шаардлагатай бөгөөд энэ нь тэнцвэрт онооны карт (ТОК)-д тусгалаа олно. Тэнцвэрт онооны картын загварын үндсэн элементүүд нь улсын секторын хувьд дараах байдлаар тодорхойлогдоно:

Хэрэглэг ийн ирээдүйн төлов: ард түмэн, нийгэм, эдийн засгийн хөгжилт

Санхүүгийн хэтийн төлов: төсвийн санхүүжилт, ард түмэнд хүлээн зөвшөөрөгдж, тэдний дэмжлэгийг авах

Эрхэм зорилго, стратеги

Хүний хөгжилт, байгууллагын осолт: ТАХ, байгууллага, салбар, ЗГ-н нэр хүнд дээшлэх

Дотоод үйл ажиллагаа: Бүтэц, зохион байгуулалт, эерэг оөр лөлт

Улсын сектор дахь тэнцвэрт онооны картын элементүүд

Төлөвлөлтийг ТОК-д илэрхийлснээр улсын секторын аль ч байгууллага, салбар, цаашид Засгийн газрын үйл ажиллагааны хэтийн төловийг нарийн хэмжилтээр харах боломжтой юм.

“Судалгааны зөвхөн үр дүн нь биш, түүнд хүргэж байгаа арга нь үнэн зөв байх ёстой”²⁵ гэдэгчлэн төсвийн төловлөлтөнд удирдлагын бүртгэлийг үр дүнтэй ашиглахад **төсөвлөлтийн аргыг** оновчтой сонгон хэрэглэх нь улсын секторын микро ба макро түвшний уялдааг илэрхийлэх, төрийн захиргааны удирдлагын бүх түвшинд үнэн зөв мэдээлэл олж авах, үр дүнд чиглэсэн дунд хугацааны төсвийн зарлагын стратегийн удирдлагыг хэрэгжүүлэхэд онцгой үүрэгтэй.

Бизнесийн байгууллагууд ашигийн талаар санаа тавьдаг бол ашигийн бус байгууллагууд нь хотөлбөрийн биелэлтийг хангахыг эрмэлздэг. Аль аль нь сайн тооцоолсон төсөвгүйгээр амжилтанд хүрэхгүй²⁶ гэж төсөв, төсөвлөлтийн ач холбогдлыг илэрхийлжээ. Удирдлагын хяналтад төсөвлөлтийн байнгын төсөв, уян хатан төсөв, капиталын төсөв, мастер төсөв гэсэн хэлбэрүүдийг²⁷ ашигладаг. Байнгын төсвийн 3 суурь байна.Үүнд:

²⁵ Н.Тунгалаг “Удирдлагын бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх зарим асуудал” Диссертаци., УБ 1999 он., Хуудас 5
²⁶ Моломжамц Д. Удирдлагын бүртгэл УБ 1999 он. Хуу-137

²⁷ James R. Martin. MANAGEMENT ACCOUNTING CONCEPTS, TECHNIQUES & CONTROVERSIAL ISSUES: Budgeting.

Хэлбэрүүд	Төсвийн тодорхойлолт
Осгөх суурь	Өмнөх жилийн төсөв дээр үндэслэдэг
Оорчлолт оруулах	Омнох жилийн тосовт үндэслэн, гэхдээ удирдлагын зүгээс шаардлагатай зарим тодотголыг нэмж оруулдаг
Тэг суурь	Аливаа үйл ажиллагааг шинээр эхлэх цэгт тулгуурладаг

Байнгын төсвийн үндсэн сууриуд, тэдээрийн онцлог

Улсын секторын өнөөгийн практикт өмнөх жилийн үзүүлэлтэд тулгуурлан төсөвлөх аргыг хэрэглэж байгаа богоод энэ нь зарим дутагдалтай байсаар байгааг дээр дурьдсан. Энэ өсгөх ба оорчлолт оруулах 2 суурьт үндэслэсэн тосовлолтийг ашиглаж байгаа хэрэг юм. Харин өөрчлөлт шинчлэлтийг зориж, илүү үр дүнд чиглэж байгаа оноогийн нохцолд “тэг суурьт тосовлолтийн арга”-ыг улсын секторт төсвийн толовлын төсвийн тодорхойлолтанд ашиглах нь зүйтгэй гэж бид сонгож байна.

Тэг суурьт тосовлолтөөр шийдвэрийн багц боловсруулж, шийдлүүдийг үзүүлсний үндсэн дээр ач холбогдолын дараалж нь санхүүжүүлдэг.

Тэг суурьт тосов бэлтгэхдээ дараах үйл ажиллагааг гүйцэтгэн:

- Шийдвэрийн багцыг боловсруулах /Одоо байгаа болон шинээр гары болох бүх нохцол байдлыг тодорхойлох/
- Шийдвэрийн багцыг зөрэглэх /Ач холбогдоор нь зөрэглэн, инновацийн тэргүүлэх чиглэлээ тодорхойлино/
- Нөөцийүдийг хуваарилах /Хамгийн чухал үйл ажиллагаанаас нь эхлэн нөөцийг хуваарилах/ зэрэг болно.

Удирдлагын хяналтын тогтолцоонд хяналтын технологи үйлдэл, орц, гары, тохируулагч гэсэн элементүүдээс бүрдэнэ. Тухайлбал:

Орцын хэмжээс: төсөв
хариуцлагын бүртгэл

Тохируулаг :
хариуцлагын бүртгэл

Гарцын хэмжээс:
гүйцэтгэл

Удирдлагын хяналтын тогтолцооны технологи

Улсын сектор бүтцийн хувьд нүсэр, үйл ажиллагааны цар хүрээний хувьд олон талын, өргөн уудам газар нутгийг хамардаг учраас хариуцлагын бүртгэл тайлагнальн хэлб рийг ашиглах нь зүйтгэй юм. Хариуцлагын товоор дамжуулан үйл ажиллагааг тосовлож, гүйцэтгэлийг хэмжих, тайлагнах үйл явцыг хариуцлагын бүртгэл гэдэг. Улсын секторт бүтээгдэхүүний ба бүтээгдэхүүний

ортогт суурилсан төсөв, төлөвлөгөө орцын хэмжээс, түүний тайлагнал гарцын хэмжээс болох ба хариуцлагын тайлагнал тохируулагчийн үүргийг гүйцэтгэнэ.

Улсын секторын төрийн захиргааны бүтэц нь ТБУСТ хуулинд зааснаар дараахаа удирдлагын түвшингүүдэд хуваагдана. Үүнд:

- Засгийн газар
- Төсвийн ерөнхийлөн захирагч
- Төсвийн ерөнхий менежер

Хариуцлагын төв бол зохион байгуулалтын бүтцээр зөвшөөрөгдсөн хариуцлагын тогтолцооны бие даасан нэгж юм. Анхан шатны нэгжээс дээд удирдлага хүртэл хариуцлагын пирамид үүсгэнэ. Уг пирамид улсын секторт өртгийн, үр дүнгийн, санхүүжилтийн товүүдэд хуваагдаж болно. Үүнд:

Санхүү
жилтийн төв

Засгийн газар

Үр дүнгийн төв

Төсвийн ерөнхийлөн захирагч

Өртөг, зардлын төв

Төсвийн ерөнхий менежер

Улсын сектор дахь хариуцлагын товүүд

Түвшин бүрийн хяналт тухайн түвшний тосовлолтгүй уялдана, төсөв хэлэлцэх явцад мөнгөн урсгал хариуцлагын пирамидын бүх товүүдэд хуваарилагдаж, баланслах ба гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тайлагнал ч бас шатанд дээрх товүүдээр нэгтгэгдэнэ. Энэхүү пирамид нь улсын секторын стратегийн удирдлагын тогтолцоотой уялдсанаар удирдлагын хяналтын тогтолцоог бүрдүүлнэ. Ийнхүү ТОК-ийг улсын секторт хэрэглэх боломжтой болно.

Дүгнэлт

- Удирдлагын хяналтын тогтолцооны хөгжилтөнд уг тогтолцооны дотоод, гадаад орчны хувьсал өөрчлөлт хүчтэй нөлөөлох болсон. Оноөдөр орчны хувьсал зөвхөн нэг улс орны хүрээнд төдийгүй олон улсыг хамарсан, даяарчлагдсан шинжтэй болж байна. Үүнтгэй холбоотой удирдлагын хяналтад зөвхөн санхүүгийн мэдээлэл биш тооны болон чанарын мэдээллүүдийг ашиглах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.
- Улсын секторт удирдлагын хяналтын тогтолцоо төгс бус байгаагийн шалтгаан нь удирдлагын хяналтын арга зүйг зохистой байдлаар тодорхойлж хэрэглэдэггүйтэй холбоотой. Энэ нь төсвийн хөрөнгийг зүй зохисгүй зарцуулах, үйл ажиллагааны үр дүнг бууруулах, эдийн засгийн боломжийг алдагдуулах зэрэгт хүргэж байна.
- Удирдлагын хяналтын тогтолцооны хөгжлийн гарааны үед үүссэн элементүүдийн зарим нь одоо ч ач холбогдоо алдаагүй, боловсронгуй болж хэрэглэгдсээр байгаагийн нэг нь төсөвлөлтийн арга юм.

Бүтээгдэхүүнд суурилсан удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж байгаа өнөөгийн нөхцөлд төсвийн төлөвлөлтөнд **тэг суурьт тосоволгийн аргыг ашигласнаар бүтээгдэхүүний өртгийг үнэн зөв тодорхойлж, түүнд үндэслэн санхүүжилтийг олгож байх нь үргүй зардал гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзлээ.**

Ашигласан ном зүй

1. “Монгол Улсын үндсэн хууль” 1992 он
2. Н.Тунгалаг . “Удирдлагын бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх зарим асуудал” Диссертацийн ажил. УБ 1999 он
3. Т. Жааваа. Нягтлан бодох бүртгэлийн онол, арга зүй: Зардал удирдлагын бүртгэл дэх хувьслын чиг ба сургалтын хандлага. “Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт” улирал тутмын сэргүүл. №1 (3) 2010 он
4. Д. Моломжамц. Удирдлагын бүртгэл. УБ 1999 он
5. Улсын салбарын удирдлага, санхүүжилтийн шинэчлэл : Үзэл баримтлал, хэрэгжилт. Удирдлагын академи., УБ 2004 он
6. James R. Martin. Management accounting concepts,techniques & controversial issues: budgeting.

Веб сайтууд:

- [www.http://legalinfo.mn](http://legalinfo.mn)
[www.scialosa.com/services/consulting](http://scialosa.com/services/consulting)
[www.http://netmba.com](http://netmba.com)
[www.http://mof.gov.mn](http://mof.gov.mn)
[www.http://NSO.mn](http://NSO.mn)
[www.http://MAAW.com](http://MAAW.com)